

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС АГЕНТЛАГ, СУМДЫН
2017 ОНЫ 08ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2017.08.31

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэгийг 17 сум, 3 тосгон болон бүсчилсэн хэлбэрээр Мандал, Сайхан, Сүхбаатар сумдад 3 удаагийн арга хэмжээг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт нийт 2690 гаруй иргэн оролцож 2333 гаруй саналын хуудас бөглүүлэн, аймгийн хэмжээнд хэлэлцүүлэгийн явц 75.5%-тай байна. Хэлэлцүүлэгийн эцсийн дүн мэдээг 2017 оны 9 дүгээр сарын 04-ний дотор сумдаас авч нэгтгэн Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Сэлэнгэ аймаг, Япон улсын Шизуока мужийн хамтын ажиллагааны хүрээнд тус тужийн Засаг дарга Кавакацү Хэйта тэргүүтэй зочид төлөөлөгчид манай аймагт албан ёсны айлчлал хийлээ. 2 тал газар тариалангийн салбарт идэвхтэй хамтран ажиллаж байгаа бөгөөд Шизуока мужийн газар тариалангийн салбарын мэргэжилтнүүд удаа дараа Сэлэнгэ аймагт ирж, Зүүнбүрэн сумын “Арвин хур” ХХК-ий 40 га талбайд Японы алдарт соба гоймонгийн гол түүхий эд болох гурвалжин будааг Япон арга технологиор тариалсан нь амжилттай ургаж байна.

Засгийн газар, Улсын Онцгой комиссын хамтарсан ОБЕГ-ын дэд дарга П.Баттогтохоор ахлуулсан ажлын хэсэг Сэлэнгэ аймагт ажиллаж, аймгийн Онцгой комиссыг хуралдуулан, холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсож, зарим үүрэг чиглэл өглөө. Хуралд аймгийн ОБГ, МХГ, УЦУОШТ, ХХААГ, ЭМГ-аас хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, 2017 онд цаг агаарт зориудаар нөлөөлсөн үйл ажиллагаа, аймгийн зуншлагын байдал, үр тарианы болц, МАА-н өвөлжилтийн байдал, цаашид авах арга хэмжээ, 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар мэдээлэл хийж, тулгамдаж байгаа асуудлуудаа танилцуулсан.

Аймгийн Засаг даргын өргөтгөсөн хуралдааныг зохион байгууллаа. Өргөтгөсөн хуралдаанд 17 сумын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд, нийгмийн салбарын төрийн үйлчилгээний байгууллагууд болон банкны удирдлагууд бүрэн хамрагдаж, сум бүр 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлаа, тулгамдаж байгаа асуудлуудын талаар танилцуулан, аймгийн удирдлагуудтай харилцан ярилцлаа. 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах аймгийн Засаг даргын албан даалгаврыг хэрэгжүүлэх, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэл, сурагчдын хичээлийн шинэ жил зэрэг цаг үеийн асуудлуудын талаар хэлэлцэж, аймгийн Засаг даргын зүгээс удирдлагын багтаа хандан үүрэг чиглэл өглөө

БОАЖЯ-наас зохион байгуулсан “Ногоон хөгжлийн хэтийн зорилт, дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах чадавх бүрдүүлэх” сэдэвт

сургалтанд хамрагдаж, “Сэлэнгэ аймгийн хөгжлийн өнөөгийн байдал” сэдвээр мэдээлэл хийлээ.

Онцгой байдлын талаар:

Монгол Улсын Шадар сайдын баталсан Газрын тос олборлодог, газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг, борлуулдаг байгууллагуудад Галын байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 6 аж ауйн нэгж, байгууллагын 6 объектод хяналт шалгалтыг хийж 34 зөрчлийг илрүүлж, үзлэг шалгалтын явцад 2 зөрчлийг арилгуулан бусад зөрчлийг арилгуулахаар Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага үйлдэж, тухайн байгууллагын дарга, эрхлэгч нарт өгсөн.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтааророн сууцны нэг давхар, зоорийн давхруудад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, гамшгаас хамгаалах, галын аюулгүйн шаардлагыг тодорхойлсон стандарт, техникийн нормативын хэрэгжилтийг шалгаж, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдалд нь үнэлгээ, дүгнэлт өгч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангуулж ажиллалаа. Уг ажлын хүрээнд Сайхан сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй 16 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт, шалгалтыгхийж нийт 103 зөрчлийгилрүүлэнүзлэгшалгалтынявцад 11 зөрчлийг арилгуулан бусадзөрчлийгарилгуулахаар Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавалбиелүүлэхалбаншаардлага үйлдэж байгууллагын дарга, эрхлэгч нарт өгч ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сумдад уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Бороо гоулд” ХХК-ийирүүлсэн хүсэлтийн дагуу 08-р сарын 07-ны өдөр тус компанийн инженер техникийн болон тусгай, туслах ажилтнуудад “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, түймрийг унтраах арга зүй” ажиллагааны талаар танхимын сургалтыг зохион явууллаа.Сургалтыг Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар онолын мэдлэг, түймэр унтраах үеийн аюулгүй ажиллагаа мөн гар багажийг хэрхэн ашиглах, түймрийн голомтыг унтраах зэрэг танхимын 2 удаагийн 3 цагийн сургалтыг зохион байгууллаа.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар олон хоног түймрийн голомтод үүрэг гүйцэтгэсэн Мандал суман дахь Онцгой байдлын хэлтсийн ГТУА 19 дүгээр ангийн 16 албан хаагчийг 08 дугаар сарын 14-нөөс 19-ний өдрийг хүртэл Онцгой байдлын ерөнхий газрын харьяа “Жаргалант”сэргээн заслын төвд эмчилгээ сувилгаанд хамруулсан.

Байгал, цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ой, хээрийн түймэр гарах эрсдэл өндөр байгаатай холбогдуулан ус, цаг уур орчны шинжилгээний албанаас цаг агаарын мэдээллийг тухай бүр авч сум орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага,иргэд, малчдад урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийн шторкыг 7 хоногт 1 удаа гол, нуурын усанд унаж осолдохоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмжийг “Миний Монгол” КАТВ-ээр 5 хоногт 2 удаагийн давтамжтайгаар тус тус хүргэсэн.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

“Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХХК-тай хамтран Баянгол суманд ээлжит цахилгааны тоолуур баталгаажуулалтаар ажиллаж, айл өрхийн хэрэгцээнд

ашиглагдаж байгаа нэг фазын 593 ш цахилгааны тоолуур баталгаажуулах ажлыг хэрэгжүүлсэн. Одоогийн байдлаар Сайхан суманд ээлжит баталгаажуулалтаар ажиллаж байна.

Хүдэр суманд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний 8 газарт тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгосон. Мөн 1 цайны газрын үйлчилгээнд арга зүйн зөвлөгөө өгсөн.

Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 4 ш жин, намрын ургац хураалтанд ашиглагдах 5 ш авто пүүг тус тус баталгаажуулсан. “Мэйжүрмэнт” ХХК-ий хүсэлтийн дагуу Хушаат болон Сайхан суманд байрлах үр тарианы үтрэмд байрлах автожинг баталгаажуулалтанд хамруулсан.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

2018 оны төсвийн төслийн саналыг 07 дугаар сарын 21-нээс сум, төсөвт байгууллагуудаас төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл бэлтгэхэд анхаарах асуудлуудад тулгуурлан хүлээн авч нэгтгэн 08 дугаар сарын 07-ноос 14-ний өдрүүдэд Сангийн яаманд хүргүүлж, нийт орлогыг 18 836.3 мянган төгрөг, зарлагыг 19 169.5 мянган төгрөгөөр хянуулж баталгаажууллаа.

Аймгийн 2017 оны хагас жилийн орон нутгийн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн нийт 17 сумын нэгтгэсэн тайлан, шууд харьцдаг байгууллагуудын санхүүгийн тайланг хянаж хүлээн авч нэгтгэн 2017 оны 08 дугаар сарын 15-наас 18-ны өдрүүдэд Сангийн яаманд хянуулан нэгтгүүллээ.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны 3-р сарын танилцуулгыг боловсруулан гаргаж, аймгийн удирдлагуудад, 17 сум, 24 хэлтэс агентлагуудад хүргүүлж, танилцуулгыг www.selenge.nso.mn хуудсаар цахим хэлбэрээр мэдээлсэн.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	10,921,648.0	12,898,754.7	118.1
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	7,718,688.6	6,690,180.6	86.7
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	48,771,305.6	42,145,076.4	86.4
	- Аймгийн төсвийн зарлагын дүн	13,450,898.3	10,900,859.7	81.0
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	398,215.0	348,097.8	87.4
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	728,578.5	124,878.2	17.1
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,626,976.1	400,607.8	24.6
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	1,490,108.2	961,072.8	64.5
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	2250,000.0	2,250,000.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	26,291,243.3	26,291,243.3	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	13,398,279.2	13,398,279.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	7,060,004.7	7,060,004.7	100.0
	- Соёлын байгууллага	1,762,501.2	1,762,501.2	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	594,474.6	594,474.6	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	3,159,832.0	3,159,832.0	100.0

	- ГХБХБГазар	132,464.7	132,464.7	100.0
	- ГБХЗХГазар	183,686.9	183,686.9	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	26,291,243.3	26,291,243.3	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	13,398,279.2	13,398,279.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	7,060,004.7	7,060,004.7	100.0
	- Соёлын байгууллага	1,762,501.2	1,762,501.2	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	594,474.6	594,474.6	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	3,159,832.0	3,159,832.0	100.0
	- ГХБХБГазар	132,464.7	132,464.7	100.0
	- ГБХЗХГазар	183,686.9	183,686.9	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	2,004,057.0	2,004,057.0	100.0
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1,226,386.0	1,201,736.5	98.0
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	491,441.0	521,233.1	106.1
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	344,100.3	344,100.3	100.0
11	Тусгай сангуудын зарлага	903,613.4	276,040.4	30.5

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2017 VI - сар	2017 VIII - сар	2017- VIII 2017-VII /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 250	1250	
	Талх /орон нутгийн, ш/	1 100	1100	
	Нарийн боов /кг/	2 200	2200	
	Будаа /кг/	2 500	2500	
	Элсэн чихэр /кг/	2 200	2200	
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 000	5200	-800
	Үхрийн мах /кг/	7 000	5800	-1200
	Адууны мах /кг/	6 000	5000	-1000
	Ямааны мах /кг/	5 000	4800	-200
	Дотор мах, цувдай /цусгүй/	3 000	2000	-1000
	Хиам /чанасан, кг/	10 000	10000	
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	600	500	-100
	Сүү / савласан, л/	2 500	2500	
	Тараг /задгай, л/	1 200	1000	-200
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13 000	13000	
	Айраг /л/	3 500	3500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 000	4000	
	Өндөг /ш/	320	320	
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	3 800	
	Өөхөн тос /кг/	1 800	1 800	
	Шар тос /кг/	10 000	10 000	
	Масло /задгай, кг/	4 000	4 000	
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	2 500	1000	-1500

	Лууван /кг/	1 500	800	-700
	Манжин /кг/	1 500	800	-700
	Байцаа /кг/	1 500	700	-800
	Сонгино /кг/	1 500	1000	-500
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 300	3300	
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 600	2600	
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1480	1 480	
	Бензин А - 92	1630	1 630	
	Дизелийн түлш	1720	1 720	

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 96 тоот тогтоолоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” аймгийн хөтөлбөрийг батлуулж газар хэлтэс, албадын дарга, сумдын Засаг дарга, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт тус тус хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2017 оны 8 дугаар сард 408 холбогдогчтой, 878,7сая төгрөгийн хохиролтой, 418 гэмт хэрэг бүртгэгдэж, 12 хэргээр буюу 2,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн гаралт Сүхбаатар сумын 6,7-р баг, Алтанбулаг, Ерөө, Мандал, Баянгол, Орхон сумдад 5.1-62.5%-иар, Хүдэр, хушаат суманд 2-2.2 дахин өсч, Сүхбаатар сумын 3,4,5,8-р баг, Шаамар, Жавхлант, Цагааннуур, Түшиг, Сант, Орхонтуул, Баруунбүрэн сумд, Дулаанхаан, Бугант тосгонд 1.4-66.7%-иар тус тус буурсан байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд 2017 оны 8 дугаар сард 244 төрөлт, 69 гэрлэлт, 18 гэрлэлт цуцлалт, 60 нас баралт бүртгэгдэж, 616 иргэнд цахим үнэмлэх, 63 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэх 3978 ширхэг олгож, аймаг, хотруу шилжин явсан 337, шилжин ирсэн 258, сум дүүрэгт шилжин ирсэн 51, сум дүүрэгт шилжин явсан 90, баг хооронд шилжин ирсэн 188, баг хооронд шилжин явсан 190 шилжилт хөдөлгөөн бүртгэгдээд байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлд 695 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 938 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамжийн 113275 төгрөг, үйлчилгээний хураамжийн 12509068 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварт 26548500 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

Архивын тасаг:

Монгол Улсад орчин цагийн Архивын байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан салбарын болон яамны шагналаар шагнагдах сумдын болон төр төсвийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын судалгааг гаргаж АЕГ-т хүргүүлсэн.

Шинээр баригдсан барилга байгууламжийн зураг төсөл, техникийн баримт бичиг хүлээн авах ажлын хүрээнд “Есөн эрдэнэ” ХХКомпаний Хүдэр, Жавхлант сумын зам засвар, тэмдэг тэмдэглэлгээ, “Ниши илч” ХХКомпаний Хүдэр сумын цэвэрлэх байгууламжийн засварын гүйцэтгэлийн ажил, Спорт сургуулийн сантехникийн засвар, “Хүчит Сэлэнгэ” ХХКомпаний Нэгдсэн эмнэлгийн дотор засварын ажлын баримтуудаар сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийсэн.

Нягтлан шалгалтыг хийх ажлын хүрээнд 2 хөмрөгийн 47 хадгаламжийн нэгжийн 5935 хуудсыг скайнердаж мастер хувь үүсгэн цахим хэлбэрт оруулсан.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 73 дугаар хөмрөг болох Зүүнхараа хотын Хүнсний үйлдвэрийн 1970-1998 оны 21 хадгаламжийн нэгжийн 3986 хуудас, Шаамар сумын ХАА сургуулийн 1970-1990 оны 5 хадгаламжийн нэгжийн 631 хуудсыг шивж холболт хийсэн.

Ард иргэд албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 157, цалингийн тодорхойлолт 2, магадлагаа тодорхойлолт 25-ыг гаргаж үйлчилсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

2017 онд боловсролын салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 672.3 сая төгрөг, аймгийн төсөв болон аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 162.6 сая төгрөг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 338.2 сая төгрөг нийт 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 их засвар, өргөтгөл шинэчлэлтийн ажлууд хийгдэж байна.Эдгээр ажлуудаас 12 ажил бүрэн дуусч улсын комисст хүлээлгэн өгч, хичээлийн шинэ жилийн бэлтгэлээ хангасан бол үлдсэн 5 ажил болох Сүхбаатар сумын 2 дугаар сургууль, 2 дугаар цэцэрлэгийн их засвар, Хүдэр сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөл, Мандал сумын 1 дүгээр сургуулийн дээврийн засвар, Шаамар сумын 2-р цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулж хашаа барих ажлууд 40-80 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуульд багшлах эрхийн шалгалтыг зохион байгуулах ажлын хүрээнд шалгалтанд орох хүсэлт гаргасан 98 иргэнийг бүртгэн авснаас 89 шалгуулагч 2-р шатны шалгалтанд орсон.

Сэлэнгэ аймгийн “Багш нарын бага хурал”-ыг 08 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, “Багшийн ёс зүйн харилцаа”, “Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” сургалтанд нийт 828 багш, боловсролын байгууллагын удирдах ажилтанууд хамрагдсан.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2017 оны эхний 07 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 997байсан бол 102иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 80ажлын байранд 30 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 165 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 904болсон байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт Сүхбаатар, Мандал, Түшиг сумын 3 иргэнийг хамруулж ХЭДСангаас 9000.0 мян.төг-ийг зарцуулж 3 ажлын байрыг шинээр бий болголоо. Мөн Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малжуулах арга хэмжээнд Ерөө, Хүдэр, Зүүнбүрэн, Орхон сумд, Номгон тосгоны малчин өрхүүдийг хамруулсан бөгөөд 2015 оны эргэн төлөлттэй малчдаас малыг авч энэ онд дээрх хөтөлбөрт хамрагдсан залуу малчин өрхүүдэд малыг хүлээлгэн өгч малжуулж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Мандал сумын ахмадын сувилалд 20, Сүхбаатар сумын ахмадын сувилалд 31, Баянгол сумын ахмадын сувилалд 22 нийт 73 ахмад настанг 2 ээлжээр хүлээн авч амраан эмийн бус сэргээн засах, эмчилгээ сувилгаа үзүүлэн ажиллалаа.

3.Эрүүл мэндийн талаар

Баянгол, Цагааннуур, Алтанбулаг сум, Бугант тосгоны эрүүл мэндийн төвүүдийн хяналтанд байгаа 106 жирэмсэн эхийн хөтөч картын хөтлөлт, жирэмсний хяналтын явцад үнэлгээ хийж илэрсэн зөрчил дутагдалд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Зуны эмчилгээний "Буман нарс" сувилал нь нийт 5 ээлжийг 06 дугаар сарын 20-ноос 08 дугаар сарын 09-нийг хүртэл өөрийн улсын 156 ахмад настан, ОХУ-ын Буриад Улсын Хиагт болон Зэдийн районы 55 ахмад настныг тус тус хүлээн авч нийт давхардсан тоогоор 3400 гаруй удаа эмгүй, агаар эмчилгээний хэлбэрээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Элэгний В,С вирус илрүүлэх шинжилгээг аймгийн хэмжээний 40-65 насны 28910 хүний 65 хувийг эхний ээлжинд хамруулахаар 17850 оношлуур авсан ба үүнээс дээрх насны иргэдийн 62 хувийг хамруулж дуусгалаа.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

2017 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.5.6 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийгэмд тустай санал санаачилгыг өрнүүлэх зорилгоор гадаад орнуудад суралцдаг тус аймгийн харьяат оюутан залуучуудын уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтанд ОХУ, БНХАУ, БНСУ-д суралцдаг оюутнууд оролцож, санал бодлоо солилцон "Гадаад орнуудад суралцдаг Сэлэнгэ аймгийн харьяат оюутан залуучуудын холбоо"-г үүсгэн байгуулж, цаашид хийх ажил арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажиллалаа.

Аймгийн ЗДТГ-ын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 6/180 тоот захирамж, ГБХЗХГ-ын дэд даргын 2017 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 02/47 тоот чиглэлийг үндэслэн аймгийн Стандарт хэмжилзүйн газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газартай хамтран 06 дугаар сарын 29-нд Алтанбулаг суманд орших Гүннуур зусланд "Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага" MNS 5633:2013 стандартын дагуу хяналт шалгалт хийлээ. "Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны тохирлын үнэлгээний хуудас"-ны дагуу 161 үзүүлэлтээр үнэлж дүгнэхэд 125 үзүүлэлт эерэг гарч 77.6 хувьтай дүгнэгдлээ.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс нь 2017 оны 07 сарын 30-ны байдлаар 16,1 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 07 дугаар сарын 30-ны байдлаар өссөн дүнгээр 16,3 тэрбумтөгрөгийн орлого төвлөрүүлж 101хувийн биелэлттэй ажилласан.

Эрүүл мэндийн даатгалын санд төрөөс хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 1 тэрбум 121 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтөйгээс 1 тэрбум 101 сая төгрөгийг оруулж 98 хувийнбиелэлттэй ажилласан.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

2017 оны 08 дугаар сарын 3, 4, 9, 10, 11, 16, 19-ний өдрүүдэд нийт сумдын нутгаар 0,0-49,0 мм, 6-ны өдөр нутгийн баруун хэсгээр, 12-ны өдөр нутгийн зүүн хэсгээр, 14, 18-ны өдрүүдэд хойд хэсгээр 0,4-13,0 мм, 17-ны өдөр зүүн хэсгээр 0,1-11,0 мм бороо орлоо. Бусад хугацаанд хур тунадас ороогүй.

Сарын 3, 4, 9, 10, 11, 16, 18, 19-ний өдрүүдэд салхи ширүүсч 8-13 м/сек, зарим үед түр зуур ширүүсч 16-27 м/сек хүрсэн. Бусад хугацаанд салхи баруун болон баруун хойноосоо 5-10 м/сек байв. I арав хоногт шөнөдөө 12-17 градус, өдөртөө 28-33 градус дулаан, II арав хоногийн сүүлээр өдөртөө хүйтэрч 12-22 градус дулаан байв. Бусад хугацаанд шөнөдөө 11-16 градус, өдөртөө 25-30 градус дулаан.

2017 оны 08 дугаар сарын хоёрдугаар 10 хоногийн байдлаар Сэлэнгэ мөрний усны түвшин олон жилийн дунджаас 30-36 см-ээр их, Сэлэнгэ мөрний усны түвшин олон жилийн дунджаас 38-79 см-ээр бага, Орхон голын усны түвшин олон жилийн дунджаас 26-116 см-ээр бага, Ерөө голын усны түвшин олон жилийн дунджаас 35-80

см-ээр бага, Хүдэр голын усны түвшин Хүдэр сум орчмоор олон жилийн дунджаас 22 см-ээр бага, Зэлтэр голын усны түвшин Түшиг сум орчмоор олон жилийн дунджаас 11 см-ээр бага, Хараа голын усны түвшин Баянгол сум орчмоор олон жилийн дунджаас 37 см-ээр бага байна. Хур тунадас их орж байгаатай холбогдуулан цаашдаа Сэлэнгэ аймгийн гол мөрний усны түвшин өсөх хандлагатай байна.

Бэлчээрийн болон таримал ургамлын өндөр, ургалтын балл нутгийн 60 гаруй хувьд нь сайн, 25 гаруй хувьд дунд, 15 орчим хувьд нь зуншлага муу байна. Бэлчээрийн ургамлын өндөр 1-58 см байна. Улаанбуудай ургалт ихэнх сумдын нутгаар сайн, ургамлын өндөр 40-84 см. Цагааннуур, Орхон сумд сүүн бололт, Ерөө, Зүүнбүрэн, Баянгол сумд аарцан бололт, Орхонтуул суманд улаанбуудай бүрэн бололтын үе шатанд орсон.

Улаанбуудайн талбайн хөрсний чийг 0-20см-т Ерөө, Цагааннуур сумдын нутгаар хангалттай, Орхон, Баянгол, Орхонтуул сумдын нутгаар дунд, 0-50 см-т Цагааннуур, Орхон, Ерөө сумдын нутгаар хангалттай, Орхонтуул сумдын нутгаар дунд, бусад сумдын нутгаар хангалтгүй, 0-100см-т Цагааннуур, Ерөө, Орхон сумдын нутгаар хангалттай, Орхонтуул сумын нутгаар дунд, бусад сумдын нутгаар хангалтгүй. Бэлчээрийн талбайд 0-20 см, 0-50 см-т Баянгол, Ерөө, Орхон сумдын нутгаар дунд 0-100см-т Ерөө сумын дунд, Орхон хангалтгүй гэсэн үнэлгээтэй байна.

Бэлчээрийн болон таримал ургамлын хөнөөлт хортон шавьж, царцаа, мэрэгчдийн ажиглалтаарсарын II арав хоногт ихэнх сумдын нутгаар бараан далавчит, тоонолжит, барабины таршаа ажиглагдсан бөгөөд 1м² хүрээнд дунджаар 1-5 тоологдсон. Таримал ургамалд Зүүнбүрэнд бараан далавчит, гессений ялаа дунджаар 6 ажиглагдсан байна. Бусад сумдын нутгаар нисэгч болон хөнөөлт хортон шавьж ажиглагдаагүй.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын агаарын чанарын 1-р харуулын 08-р сарын 02-р арав хоногийн ажиглалтын дүнгээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.002 мг/м³, хамгийн их нь 0.003 мг/м³, азотын давхар ислийн дундаж агууламж 0.012 мг/м³, хамгийн их нь 0.020 мг/м³, агаар болон хөрсөн дээрхи цацрагийн түвшин фон түвшнээс даваагүй байна. Нийт тоосонцорын дундаж агууламж 0.020 мг/м³, хамгийн их нь 0.026 мг/м³ байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын баталсан удирдамжийн дагуу 2 ажлын хэсгийг байгуулан ургацын урьдчилсан балансыг тогтоон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. 2017 онд нийт 203,0 мянган га-д тариалалт хийсний 157,7 мянган га-д үр тариа тариалж, 19487 га-гаас ургац алдаж, 149,1 мянган га талбайн 1 га-гаас 10,6 цн буюу 149,1 мянган тн, 151,1 мянган га-д улаанбуудай тариалснаас 19126 га ургац алдаж, 134,8 мянган га талбайн 1 га-аас 10,5 цн буюу 141,0 мянган тн, 11,0 мянган га-д малын тэжээл тариалж, нэгж талбайгаас 16,6 цн буюу 23,2 мянган тн, 34,2 мянган га-д тосны ургамал тариалснаас 4933 га талбайн ургац алдаж, 29,3 мянган га талбайн 1 га-аас 6,1 цн буюу 17,9 мянган тн ургац, 2572 га-д төмс тариалснаас 64,7 га талбайн ургац алдаж, 2432 га талбайгаас 122,5 цн буюу 29,8 мянган тн, 2476 га-д хүнсний ногоо тариалснаас 112,6 га талбайн ургац алдаж, 2363,5 га-гаас 129,4 цн буюу 30,5 мянган тн ургац хураан авах төлөвтэй байна.

Сумдын ХАА-н тасгаас зуншлагын байдал, ургацын төлөв, мал өвөлжилтийн бэлтгэл ажлын урьдчилсан дүн мэдээг авч нэгтгэн дүгнэлт хийж салбарын яамнаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт, ургац, хадлан тэжээл хураах бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 1/714, ХХААГ-ын даргын 2017 оны “Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” 257, 258 дугаар албан бичгүүдийг сумдад хүргүүлээд байна.

Засгийн газрын 186 дугаар тогтоолоор аймгийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс, 30 тн тэжээл, сумын нөөцөд 1700 тн өвс, 510 тн тэжээл бэлтгэх үүрэг даалгавар өгсөнийг тухайн сумын малын тоонд харьцуулан бэлтгэх өвс, тэжээлийн хэмжээг тогтоон сумдад хүргүүлэв. Сумдаас өвөлжих нийт малын тоо, отроор өвөлжих малчин өрхийн тоо, бэлтгэх хадлан, тэжээл, зах зээлд нийлүүлэх мал, махны судалгааг авч нэгтгээд байна.

Зуншлага, өвөлжилтийн бэлтгэл ажил Түшиг сум зуншлага сайтай, Мандал, Баянгол, Орхонтуул, Орхон, Сайхан, Сант, Баруунбүрэн, Хүдэр сум гантай, бусад сум гандуу байлаа. Гантай байсан дээрхи сумуудад 5,5 мян. малчин болон мал бүхий өрхийн 936,3 мян. толгой мал зусаж байна. 7 сарын сүүлээр орсон бороо газрын өнгийг сэргээх төлөвтэй байгаа ч хадлан хадах хэмжээнд сэргээгүй. Гэвч 8-р сарын сүүл гэхэд дээрхи 8 сумаас бусад сумууд тодорхой хэмжээний байгалийн хадлан бэлтгэх боломж бүрдэх төлөвтэй байна. Орон нутагт хадлан бэлтгэх ажил 08 дугаар сарын 20-ноос эхэлсэн.

Аймгийн хэмжээнд 17 сумын 54 багт 9,5 мянган малчин болон мал бүхий өрхөд 1,6 сая толгой мал өвөлжинө. Одоогийн байдлаар малчид орон нутагтаа отор нүүдэл хийж, мал сүрэгтээ тарга тэвээрэг авахуулах ажлыг хийж байна. Харин Мандал, Баянгол, Орхонтуул сумаас болон Төв, Булган аймгийн зарим сумдаас Ерөө, Алтанбулаг, Түшиг, Цагааннуур, Хушаат зэрэг сумдын нутгаар отор нүүдэл хийх саналаа ирүүлээд байгаа боловч ургац хурааж дуусах хүртэл орохыг түр хориглоод байна. Зуншлага гантай байгаа сумдад энэ байдлаар үргэлжилвэл дээрхи сумын малчдыг хаана өвөлжүүлж, хаваржуулах боломж байгааг судалж байна. Эдгээр сумуудад 7397,3 толгой мал бүхий 2,4 мянган малчин өрх байгаагаас хэт гантай байсан Мандал, Баянгол, Орхонтуул сумын 392,7 мян. тол мал бүхий 1,3 мян. малчин өрх байна. Хилийн зурвас бүсэд байнга өвөлждөг 40 өрхийн 10 мянга гаруй мал өвөлжинө.

Европын холбооны “Нэмүү өртгийн сүлжээ” төслийн байгууллага, ХХААХҮ-ийн яамнаас 2017.08.09-ны өдөр Сүхбаатар суманд сүү, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч нарын дунд нэг өдрийн сургалтыг зохион байгуулж 50 гаруй иргэн оролцлоо.

НҮБ-ийн ХХААБ-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Гангаас улбаатай зудын хүндрэлийг эрсдэл багатай даван туулахад яаралтай тусламж үзүүлэх чадвахийг сайжруулах” төслөөс 2017.08.10-ны өдөр нэг өдрийн сургалтыг сумдын ХАА-н тасгийн МАА-н үйлдвэрлэл, үржил, бүртгэл хариуцсан мэргэжилтэн нарыг хамруулан зохион байгууллаа. Сургалтанд 15 сумын мэргэжилтэн хамрагдлаа.

Сүхбаатар, Мандал, Орхонтуул, Зүүнбүрэн зэрэг сумдаас ирсэн өвчилсөн, хорогдсон мал, амьтны 21 эмгэгт дээжинд стандарт арга зүйн дагуу оношлогоо шинжилгээг хийж, УМЭАЦТЛ-иор баталгаажуулан хариуг маягтын дагуу гаргуулан авч холбогдох мал эмнэлгийн нэгж болон иргэдэд өгсөн бөгөөд халдварт өвчний үүсгэгч ирлээгүй.

Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораториос баталсан “Гахайн зарим өвчнүүдийн лабораторид суурилсан тандалт судалгааны ажлын удирдамж”-ийн дагуу Сэлэнгэ аймгийн МЭА-ны эмч мэргэжилтнүүд Мандал, Баягол, Сүхбаатар сумдын өрхөөс нийт 60 гахайнаас цус авч, ийлдсийг ялган бүртгэлжүүлэн зарим архаг болон гоц халдварт өвчний шинжилгээ хийх, Аж ахуй эрхлэлтийн байдал, гахайн гарал үүсэл, вакцинжуулалтын мэдээлэл сүрэг сэлбэлт, биоаюулгүй байдлын талаар мэдээлэл, асуумж цуглуулж, авсан дээж бүрийг бүртгэлийн цахим хэлбэрт оруулж хөтөлсөн.

Худалдан борлуулагдаж буй төв нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж байгаа мал, аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний Адууны махны 5 дээж, 615 кг, үхрийн махны

69 дээж 8763 кг, хонины махны 141 дээж 3241 кг, сүүний 127 дээж 3927 л, дайвар 13 дээж 390кг, өндөгний 217 дээж 3847 ш дээжинд тус тус МЭАЦ-ийн магадлан шинжилгээг хийж баталгаажуулалж гэрчилгээ олгов. Халдварт өвчний сарын мэдээг файлаар болон бичгээр УМЭҮГ-т хүргүүлсэн.

“Мал эмнэлгийн тухай ойлголт, эмийн зүй зохистой хэрэглээ” сэдэвт сургалтыг Алтанбулаг, Ерөө, Орхон суманд давхардсан тоогоор 56 иргэд, малчид, малын эмч нар, сурагчдад хийж зөвлөмж танилцуулга гарын авлагаар хангасан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын санаачлагаар зохион байгуулагдсан төвийн бүсийн ХХАА-н мэргэжилтнүүдийн сургалт урлаг сортын арга хэмжээний үеэр малын гоц халдварт өвчний үеийн “Хээрийн мал эмнэлэг дэлгэх” үзүүлэх сургуулилтыг Баруунбүрэн сумын Амарбаясгалант хийд дээр зохион байгуулж Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн хөдөлгөөнт бүлгийн үйл ажиллагаа, чиг үүрэг гоц халдварт өвчин гарсан үед мал эмнэлгийн нарийн мэргэжлийн бүлгийг зохион байгуулж голомтыг тогтоон дээж авч шинжлэн оношлох, урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх, хорио цээр тогтоох, ариутгал халдваргүйжүүлэлт хийх зэргийг үзүүлсэн. Мөн нарийн мэргэжлийн бүлгийн бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах сургууль, сургалтанд сургаж дадлагажуулах гоц халдварт өвчин гарсан үед шуурхай оношлох, учирах хохиролыг багасгах арга хэмжээг авч ажиллах талаар МХГ, ОБГ, мэдээлэл, заавар зөвлөгөө зөвлөмж өгч хамтран ажилласан.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

1.Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын талаар:

Аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 20-ны А/331 тоот захирамжаар байгуулагдсан эвдэрсэн газрын нэгдсэн тооллогын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оржБаянгол, Ерөө, Мандал, Орхонтуул, Түшиг, Хүдэр сумдад2017.07.25-ны өдрөөс 2017.08.10-ны өдрийг хүртэл ажиллаж нийт94 эвдэрсэн газрын байршил бүхий 3635,03 га газрыг тогтоон, солбицолжуулан зурагжуулж мэдээллийн сан үүсгэн бүртгэлжүүлсэн.

Газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг зориулалтаар нь бүртгэн баталгаажуулах ажлын хүрээнд Ерөө сумыннутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлыг “Вектор мэл” ХХК-тай хамтран 08 дугаар сарын 21-нээс 23-ныг хүртэл ажиллаж суурь судалгаа болон малын дөрвөн улирлын бэлчээрийн хуваарь, багийн хэсгийн хил, өвөлжөө хаваржаа, зуслан, намаржааны байршлыг шинэчилэн тогтоов. Тус ажлыг сумын газрын даамал, Хөдөө аж ахуйн тасгийн мал эмнэлэг үржлийн мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагч, Сум дундын ойн анги, хоёр багийн Засаг дарга, Бугант тосгоны захирагч, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн, Жавхлант, Зүүнбүрэн сумын газрын даамлууд хамтран гүйцэтгэлээ.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг Фото мониторингийн аргаар үнэлэх хянах хээрийн хэмжилтийн ажил хийгдэж 17 суманд нийт 90 цэг байгууллаа.

Тариалангийн болон атаршсан газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлаар 15 тариалангийн болон уриншилсан газраас дээж аван бичиглэл хийж гүйцэтгэсэн.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг “Нишин илч” ХХК гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өглөө.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын төвд хайрган хучилттай авто зам барих ажлыг “Сэлэнгэ Есөн Эрдэнэ” ХХК, Хушаат сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажлыг “Өнөр Зам” ХХК тус тус гүйцэтгэж дууссаны дараа Улсын комисс ажиллалаа.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын талаар:

Ойн хөнөөлт шавжийн хэт олшролттой байгаа Баруунбүрэн суманд 8000 га талбайд, Сант суманд 4000 га талбайд хийгдсэн ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлын гүйцэтгэлийг газар дээр нь үзэж танилцлаа.

Ерөө сумын ойн сангийн талбайд гүйцэтгэж буй ой зохион байгуулалтын ажлыг хэрхэн гүйцэтгэх талаар ойн мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийг хамруулан гүйцэтгэгч байгууллага болох “Мөнх ногоон жодоо” ХХК-тай хамтран зөвлөлгөөнзохион байгууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Ц.Батбаярын ахалсан ажлын хэсэгтэй хамтран Хүдэр сумын ойн санд гарсан түймрийн голомт дээр ажиллалаа.

2017 оны 07 дугаар сард Шаамар сумын Охиндий/Нарсан сүүл/ чиглэлд гарсан хүчтэй салхины улмаас мод хугарч, булгарч унасныг Сэлэнгэ-Бэлчирийн бүсийн сум дундын Ойн ангийн ажлын хэсэг газар дээр нь ажиллан 300 ширхэг буюу 405.6 м3 мод унаж экологид 68 сая төгрөгийн хохирол учирсан болохыг тогтоосон байна.

Долоо.Сум орон нутгийн талаар:

Алтанбулаг сум:

“Өнөөдрөөс эхлэн тогтмол хугацаанд цусаа бэлэглэе” сэдэвт аяныг аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран зохион байгуулж, арга хэмжээний үеэр “Энэрэнгүй үйлстэн” донор сумаар шалгарч, сумын ЭМТ-ийн нярав Д.Чулуунцэцэг МУЗН-ийн “Хүндэт донор” цол тэмдгээр шагнагдлаа.

Баянгол сум:

Сумын Засаг даргын 2017 оны “Насанд хүрээгүй хүмүүст ахуйн хэрэглээний хий /газ/-г худалдан борлуулахыг хориглох тухай” А/158 дугаар захирамжийг гаргаж, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний газруудад хүргүүлэн хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгон биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Мандал сумын “Хачи Оч” лабораторийн эмч нарын 08 дугаар сарын 10-наас 13-ны өдрүүдэд ирж ажиллан сургуулийн багш, ажилчид, дотуур байрны сурагчдад урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан.

Газрын кадастрын зураглал хийх ажлыг “Сод Сүрвэй” ХХК-тай хамтран сумын төвд болон бусад суурьшлын бүсүүдэд зохион байгуулж 95 иргэний өмчилсөн болон эзэмшиж буй газарт зураглалт хийн цэг тэмдэгтийг тухайн иргэдэд хүлээлгэн өгсөн.

Баруунбүрэн сум:

Аймгийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны 31/239 тоот зөвлөмжийн дагуу болзошгүй галын түймрийн болон үер усны аюулаас урьдчилан сэргийлэх тухай сэрэмжлүүлгийг сумын ард иргэд, олон нийтэд танилцуулах ажлыг багийн Засаг дарга, байгаль хамгаалагч нар болон сумын Засаг даргын захирамжаар томилогдсон морьт эргүүлүүдийн оролцоотойгоор хийж гүйцэтгэлээ.

2017 оны 08 дугаар сарын 15, 16–ны өдрүүдэд Орхон бүсийн Соёлын төвийн хамт олон “Бид малчидтайгаа хамт” өдөрлөг зохион байгуулж,Ивэнгийн 1-р багийн малчдын дунд урлагийн тоглолт, үндэсний бөхийн барилдаан, эмэгтэй сумо, буухиа тэмцээнийг зохион байгууллаа.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малчин өрхийг малжуулах арга хэмжээнд 6 малчин өрхийг хамруулан нийт 27 тугалтай үнээг хүлээлгэн өгөөд байна.

Сайхан сум:

Сумын Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 2.5.9. дахь заалт, Гэр бүлийн хөгжлийг дэмжих “Жаргалтай гэр бүл” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад зорилгоор “Аавуудын баяр”-ын арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аяны хүрээнд Сайхан сумын Сум дундын цагдаагийн тасагтай хамтран шинээр хэрэгжиж буй “Зөрчлийн тухай” хууль, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль” “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-аар сургалт зохион байгуулж, ажилтнуудын хуулийг мэдлэгийг дээшлүүлж ажиллалаа.

Сайхан сумын Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/103 тоот захирамжийн дагуу ил задгай зөвшөөрөлгүй худалдаа үйлчилгээ явуулж буй иргэдэд мэдэгдэл хүргүүлэх болон бараа бүтээгдэхүүний гарал үүслийн бичгийг шалган, зөвлөмж өгч ажиллалаа.

Орхон сум:

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 39 дүгээр тогтоол, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017 оны А/326 тоот захирамжийн хүрээнд сумын Засаг даргын 2017 оны А/101 тоот захирамжаар Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг сумын хэмжээнд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг орон нутгийн иргэдээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 5 өрхийг хамруулан өрх тус бүрт 5 тугалтай үхэр буюу 25 тугалтай үхрийг холбогдох журмын дагуу хүлээлгэн өглөө. Тус хөтөлбөрт 2015 онд Орхон, Сант сумаас хамрагдсан 9 өрхөөс 17 тугалтай үхрийг эргэн төлөлтөнд тусгагдсан гэрээний дагуу акт үйлдэн хүлээн авч шинээр хамрагдаж буй 5 малчинд хүлээлгэн өгч 8 тугалтай үхрийг тус бүр нь 900000 төгрөгөөр худалдан авсан.

Сумын Засаг даргын шийдвэрээр хадлангийн зориулалтаар олгох боломжтой газруудыг тогтоох зорилгоор Мангирт, Мэргэншувуут, Шархөтөл, Нүхэнгийн нам, Ёлзэрэг 880 гаталбайд хэмжилтхийсэн.

Шаамар сум:

Сумын Засаг даргын 2017 оны А/85 тоот захирамжаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг орон нутгийн хэмжээнд хэлэлцүүлэх ажлын төлөвлөгөө, алслагдсан багийн хэсгийн иргэдээр хэлэлцүүлэх ажлын хуваарийг гарган батлуулж, 2017 оны 08 дугаар сарын 04-ний өдөр сумын нийт төр, төсвийн байгууллагууд байгууллага дээрээ зохион байгуулж хуулийн төслийн талаар санал авах хуудсыг бөглүүлэн нэгтгэж аймгийн Хууль зүйн хэлтэст хүргүүлсэн. Сумын хэмжээнд нийт 329 иргэн, 8 төсвийн байгууллагын ажилтан албан хаагч, оролцож санал бодлоо илэрхийлж санал асуулгад идэвхтэй оролцлоо.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 04 тоот албан даалгавар, сумын Засаг даргын А/34 тоот захирамжаар сумын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын нэгдсэн төлөвлөгөөг батлуулан сум, тосгоны өвөлжилтийн бэлтгэл ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, хүлээн авах ургацын урьдчилсан тогтоолт явуулах, ургац хураалтыг чанартай зохион байгуулахад хяналт тавих ажлын хэсэг, төр, төсвийн байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажилд хяналт тавих ажлын хэсэг, мал аж ахуйн урьдчилан сэргийлэх, иргэдээр хадлан тэжээл бэлтгүүлэх, хяналт тавих ажлын хэсгүүдийг байгуулсан.

Сумын нутаг дэвсгэрт 2017 оны 07 дугаар сарын 11-ны өдөр байгалийн аюулт үзэгдэл болж хүчтэй салхи, шуурга шуурч хүчтэй мөндөр орсны улмаас 130 гаруй иргэний тарьсан төмс, хүнсний ногоо мөндөрт цохиулж ургац хураах боломжгүй болсоныг газар дээр нь очиж ажиллан 600 тн хүнсний ногоо өртөн 509.5 сая төгрөгийн хохирол учирсан болохыг тогтоож, аймгийн ХХАА-н газар, Онцгой байдлын газарт холбогдох материалыг хүлээлгэн өгсөн.

Сүхбаатар сум:

“Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 39 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг орон нутгийн иргэдээр хэлэлцүүлэх ажлын хэсгийг байгуулан ажиллалаа.

Монгол Улсын “Усны тухай” хуулийн 7.3 17.4 18.1.5 дахь хэсэгт заасны дагуу усны тооллогыг зохион байгуулж тайланг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүллээ. Сүхбаатар суманд усны эх үүсвэрийн тооллогоор айл өрхийн хөрсний худаг 812 ширхэг, гүний худаг 12 ширхэг, инженерийн хийцтэй худаг 17 ширхэг, зөөврийн худаг 14 ширхэг, 1 мөрөн / Сэлэнгэ мөрөн / 2 гол /Орхон гол/, /Буурийн гол/ 1булагтай /Шар хөвийн булаг/ байна.

Сүхбаатар суманд 20-иос дээш албан хаагчтай төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, ажилтнуудын судалгааг гарган Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүллээ. Судалгаанд нийт 27 аж ахуйн нэгж байгууллагын 87 мэргэжилтэн хамрагдлаа.

Хушаат сум:

Мал эмнэлэг үржлийн нэгжүүдийг угаалга, ариутгал халдваргүйжүүлэлтэнд гаргаж угаалга 25600 толгой малд, ариутгал халдваргүйжүүлэлтэнд 1700м² өвөлжөөболон өтөг бууц, задгай хашаа хамруулсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээний судалгааг авч аймгийн ХХҮГазарт хүргэв. Оны эхний 8 сарын байдлаар нийт 29 ажилгүй иргэн байгаагаас үүнээс эмэгтэй 18 байна.Насны байдлаар авч үзвэл 16-24 настай 2, 25-34 настай 9, 35-44 настай 8, 45-60 настай 10, боловсролын байдлаар авч үзвэл дээд боловсролтой 12, техникийн болон мэргэжлийн анхан шатны 7, бүрэн дунд 5, бүрэн бус дунд боловсролтой 6 иргэн тус тус байна.

Хүдэр сум:

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн болон ИТХ-ын ээлжит бус хуралдаанаар өвөлжилтийн бэлтгэл ажил, үр тариа, улаанбуудай, төмс хүнсний ногооны зоорь агуулахын бэлэн байдал, хөдөө аж ахуйн техникийн засвар үйлчилгээний бэлтгэл ажлын талаарх мэдээлэлийг авч хэлэлцсэн.

Сумын Засаг даргын зөвлөлийн хурал 3 удаа хуралдаж цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон цаг үетэй холбоотой асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Хурлаар дараах асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

1. ИТХуралд оруулах тодотголын талаар хэлэлцэх
2. Өвөлжилтийн бэлтгэл байдал хангах
3. Тендерийн ажлыг эрчимжүүлэх
4. Усан санг Хүдэр тохижилтт ААТТӨҮГ-т хүлээлцэх
5. Төрийн сангийн мэргэжилтэнг томилон ажилуулах
6. Махны дэлгүүрийг нээх гэх зэрэг ажлуудыг хэлэлцсэн байна.

Сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг сумын хэмжээнд бизнесийн зориулалтаар олгох хадлангийн талбай хэмжээг тогтоож 3424га талбайг өргөдөл хүсэлтээс гаргасан 8 аж ахуйн нэгж, 69 иргэдэд хадлангийн газрыг хуваарилан өгч гэрээ байгуулан аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээнд сумын аюулгүй нөөцөд 6000 боодол өвсийг бүрдүүлэх талаар тусгасан.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР